



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/105

Зуунмод

Түүх, соёлын хөдлөх дурсгалт
зүйлийн тооллогыг зохион байгуулах
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.1.1, 16.1.5, 26 дугаар зүйлийн 26.1, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам”-ын 2.2, Соёлын сайдын 2023 оны “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх тухай” А/317 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогыг аймгийн музей болон сумдын орон нутаг судлах танхимуудыг хамруулан зохион байгуулсугай.

2.Тооллого зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Тунгалаг (Аймгийн Соёл, урлагийн газрын дарга)

Гишүүд:

А.Хажидмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын нийгмийн Нийгмийн бодлогын хэлтсийн Ахлах мэргэжилтэн)

Н.Мөнхсайхан (Аймгийн Музейн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Э.Оюун (Аймгийн Музейн эрдэм шинжилгээний ажилтан)

С.Сувдаа (Аймгийн музейн арга зүйч)
(27 Сумын Соёлын төвийн дарга нар)

Нарийн бичгийн дарга:

Г.Дагмидмаа (Аймгийн музейн бүртгэл мэдээллийн санч)

3.Тооллогын ажлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, нэгдсэн дүн, цаашид авах арга хэмжээний санал, тайлан мэдээллийг хугацаанд нь дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Б.Тунгалаг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Д.МӨНХБААТАР